



## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДГА-2025/4/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Сайншанд сум  
2025 он

Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Цахим хаяг: [gan-ulziit@audit.gov.mn](mailto:gan-ulziit@audit.gov.mn)

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: [oyuntulkhuur.u@audit.gov.mn](mailto:oyuntulkhuur.u@audit.gov.mn)

Ахлах аудитор: Э.Энхцэцэг

Цахим хаяг: [enhtsetsege@audit.gov.mn](mailto:enhtsetsege@audit.gov.mn)

Аудитор: М.Дүүрэнжаргал

Цахим хаяг: [duurenjargalm@audit.gov.mn](mailto:duurenjargalm@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайшуванд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734  
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.03.25 № 1-6/330

тгний \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДЭЛГЭРЭХ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА О.БАТХҮҮ ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дэлгэрэх сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сумын 100 жилийн ойн хүрээнд нийт 89.8 сая төгрөгөөр 3 морины хөшөөг шинээр байгуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх", 13 дугаар зүйлийн 13.3.1-т "хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах ажлыг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад тусгахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Мөн сумын Засаг даргын Тамгын газрын төрийн үйлчилгээний 11 албан хаагчид хууль тогтоомжид нийцээгүй нийт 10.3 сая төгрөгийн мөнгөн дэмжлэгийг цалингийн зардлаас олгосон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-тай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

442507140

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Асуудлыг онцолсон хэсэг байхгүй болно.

### **Аудитын гол асуудал**

1. Сумын Орон нутгийн хөгжлийн сан нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан "Сумын наадмын талбайн тохижилт", "Гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх" гэсэн 2 ТАХ-ны урьдчилгаа санхүүжилтийг гэрээнд тусгагдсан дүнгээс нийт 11.0 сая төгрөгөөр илүү олгосон байна.
2. Сумын Орон нутгийн хөгжлийн сан нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдаагүй "Мал нядалгааны цэгийн цахилгаан дамжуулах агаарын шугам" гэх ажлын зураг төсвийн зардлын үлдэгдэл болох 1.5 сая төгрөгийг тайлант онд санхүүжүүлсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд тус сумын 100 жилийн ойн баяр наадам тохиосон бөгөөд тус арга хэмжээний зардлыг хувь хүний дансаар хандив цуглуулан зарцуулсан байна. Энэ нь Төрийн аудитын байгууллагаас хяналт хэрэгжүүлэх боломжгүй нөхцөлийг үүсгэж, санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт тус мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>490,636.30</b>	<b>618,139.00</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	136,307.10	95,932.70
33	АВЛАГА	177,372.00	164,485.00
34	УРЬДЧИЛГАА	-	9,300.00
35	БАРАА МАТЕРИАЛ	176,957.30	348,421.20
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,497,310.60</b>	<b>2,395,024.30</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,497,310.60	2,395,024.30
39200	Биет хөрөнгө	1,451,239.20	2,347,614.90
39300	Биет бус хөрөнгө	46,071.40	47,409.40
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,987,946.90</b>	<b>3,013,163.30</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,049.00</b>	<b>21,585.40</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,049.00	21,585.40
41300	Өглөг	7,049.00	21,585.40
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,980,897.90</b>	<b>2,991,577.90</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,980,897.90	2,991,577.90
51100	Засгийн газрын оруулсан капитал	435,340.50	435,340.50
51200	Хуримтлагдсан үр дүн	1,380,716.10	2,391,396.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	164,841.20	164,841.20
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,987,946.90</b>	<b>3,013,163.30</b>

### 1.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,988,076.90</b>	<b>3,244,339.00</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	259,602.00	435,618.30
110	Орлогын албан татвар	185,586.60	347,510.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	185,586.60	347,510.50
113	Хөрөнгийн албан татвар	30,773.30	15,262.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	43,242.10	72,845.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	667,884.20	1,377,205.10
120	Нийтлэг татварын бус орлого	667,884.20	1,377,205.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,060,590.60	1,431,515.60
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,593,470.40</b>	<b>2,139,908.50</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,593,470.40	2,139,908.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,851,665.40	2,139,708.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	541,116.20	816,275.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,282.80	101,791.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,614.90	241,755.60
2104	Хангамж, бараа материалын зардал	687,060.80	608,932.20
2105	Нормативт зардал	1,084.20	2,189.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,958.40	50,933.20
2107	Томилолт, зочны зардал	4,358.30	6,602.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,916.60	40,116.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	477,273.20	271,113.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	741,805.10	200.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>394,606.40</b>	<b>1,104,430.50</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>364.60</b>	<b>81,038.30</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>394,241.80</b>	<b>1,023,392.20</b>

### 1.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,698,026.00	-	1,698,026.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(111,370.00)	-	(111,370.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,586,656.00	-	1,586,656.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	394,241.80	-	394,241.80
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,980,897.90	-	1,980,897.90
9	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,980,897.90	-	1,980,897.90
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(12,712.20)	-	(12,712.20)
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,968,185.70	-	1,968,185.70
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
13	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
14	Зарласан ногдол ашиг	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	1,023,392.20	-	1,023,392.20
16	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,991,577.90	-	2,991,577.90

### 1.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,357,004.70	2,073,308.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	259,602.00	435,618.30
110	Орлогын албан татвар	185,586.60	347,510.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	185,586.60	347,510.50
113	Хөрөнгийн албан татвар	30,773.30	15,262.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	43,242.10	72,845.50
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	7,661.20	35,097.00
1181	Газрын төлбөр	35,580.90	37,748.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	36,812.00	23,587.40
120	Нийтлэг татварын бус орлого	36,812.00	23,587.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,060,590.60	1,614,102.30
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,406,906.40	2,091,109.50
21	УРСГАЛ ЗАРДАЛЫ	2,406,906.40	2,091,109.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,123,724.40	1,570,827.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	538,627.60	807,531.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,282.80	96,457.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,614.90	241,755.60
2104	Хангамж, бараа материалын зардал	34,558.40	52,500.70
2105	Нормативт зардал	600.00	135.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,545.00	56,700.90
2107	Томилолт, зочны зардал	4,358.30	6,602.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	140,777.40	291,621.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	298,360.00	17,522.20

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,283,182.00	520,281.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(49,901.70)	(17,801.50)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	14,704.80	22,572.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,704.80	22,572.90
2200	Дотоод эх үүсвэрээр	14,704.80	22,572.90
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(14,704.80)	(22,572.90)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(64,606.50)	(40,374.40)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	200,913.60	136,307.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	136,307.10	95,932.70

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,954,257.00</b>	<b>1,820,059.74</b>	<b>134,197.26</b>	<b>93.13%</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,954,257.00</b>	<b>1,820,059.74</b>	<b>134,197.26</b>	<b>93.13%</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,423,421.00</b>	<b>1,299,777.89</b>	<b>123,643.11</b>	<b>91.31%</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>839,797.50</b>	<b>807,531.55</b>	<b>32,265.95</b>	<b>96.16%</b>
210101	Үндсэн цалин	353,356.00	369,837.88	(16,481.88)	104.66%
210102	Нэмэгдэл	380,948.50	360,928.23	20,020.27	94.74%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,080.00	54,354.93	3,725.08	93.59%
210104	Урамшуулал	47,413.00	22,410.51	25,002.49	47.27%
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>105,574.70</b>	<b>96,457.89</b>	<b>9,116.81</b>	<b>91.36%</b>
210201	Тэтгэврийн даатгал	71,982.80	66,089.36	5,893.44	91.81%
210202	Тэтгэмжийн даатгал	8,398.00	7,652.41	745.59	91.12%
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,718.50	6,128.60	589.90	91.22%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,679.50	1,523.70	155.80	90.72%
210205	Эрүүл мэндийн даатгал	16,795.90	15,063.82	1,732.08	89.69%
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>263,578.90</b>	<b>241,755.60</b>	<b>21,823.30</b>	<b>91.72%</b>
210301	Гэрэл, цахилгаан	27,799.50	20,261.11	7,538.39	72.88%
210302	Түлш, халаалт	218,666.80	210,388.09	8,278.71	96.21%
210303	Цэвэр, бохир ус	17,112.60	11,106.39	6,006.21	64.90%
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,418.00</b>	<b>34,948.58</b>	<b>469.42</b>	<b>98.67%</b>
210401	Бичиг хэрэг	7,670.00	7,453.80	216.20	97.18%
210402	Тээвэр, шатахуун	20,894.00	20,805.80	88.20	99.58%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,260.00	3,879.18	380.82	91.06%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	494.00	494.00	-	100.00%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,100.00	2,315.80	(215.80)	110.28%
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>600.00</b>	<b>135.30</b>	<b>464.70</b>	<b>22.55%</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600.00	135.30	464.70	22.55%
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>68,200.00</b>	<b>67,223.81</b>	<b>976.19</b>	<b>98.57%</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,650.00	10,469.90	180.10	98.31%

210602	Тавилга	15,000.00	15,045.00	(45.00)	100.30%
210604	Урсгал засвар	42,550.00	41,708.91	841.09	98.02%
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,153.00</b>	<b>6,602.00</b>	<b>1,551.00</b>	<b>80.98%</b>
210702	Дотоод албан томилолт	8,153.00	6,602.00	1,551.00	80.98%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>88,548.90</b>	<b>31,600.97</b>	<b>56,947.93</b>	<b>35.69%</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	86,261.90	30,089.65	56,172.25	34.88%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	330.00	-	330.00	0.00%
210803	Даатгалын үйлчилгээ	700.00	434.25	265.75	62.04%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	271.00	177.07	93.93	65.34%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	86.00	-	86.00	0.00%
210807	Газрын төлбөр	900.00	900.00	-	100.00%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,550.00</b>	<b>13,522.20</b>	<b>27.80</b>	<b>99.79%</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,500.00	5,499.50	0.50	99.99%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,050.00	8,022.70	27.30	99.66%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>530,836.00</b>	<b>520,281.85</b>	<b>10,554.15</b>	<b>98.01%</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>527,036.00</b>	<b>516,521.85</b>	<b>10,514.15</b>	<b>98.01%</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	527,036.00	516,521.85	10,514.15	98.01%
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,800.00</b>	<b>3,760.00</b>	<b>40.00</b>	<b>98.95%</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,800.00	3,760.00	40.00	98.95%
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,954,257.00</b>	<b>1,779,685.35</b>	<b>174,571.65</b>	<b>91.07%</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>449,036.00</b>	<b>449,036.00</b>	<b>-</b>	<b>100.00%</b>
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	449,036.00	449,036.00	-	100.00%
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,370,921.00</b>	<b>1,313,378.09</b>	<b>57,542.91</b>	<b>95.80%</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,370,921.00	1,313,378.09	57,542.91	95.80%
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>134,300.00</b>	<b>17,271.26</b>	<b>117,028.74</b>	<b>12.86%</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000.00	12,497.66	(2,497.66)	124.98%
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,500.00	4,773.60	27,726.40	14.69%
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	91,800.00	-	91,800.00	0.00%
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>62.00</b>	<b>62.00</b>	<b>-</b>	<b>100.00%</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>6.00</b>	<b>6.00</b>	<b>-</b>	<b>100.00%</b>
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00	-	100.00%
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>28.00</b>	<b>28.00</b>	<b>-</b>	<b>100.00%</b>
620001	Удирдах ажилтан	9.00	9.00	-	100.00%
620002	Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.00%
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-	100.00%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	293,622.64	(293,622.64)
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	293,622.64	(293,622.64)
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	293,622.64	(293,622.64)
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	17,552.14	(17,552.14)
210402	Тээвэр, шатахуун	-	16,576.94	(16,576.94)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	975.20	(975.20)
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	12,050.00	(12,050.00)
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	219.00	(219.00)
210604	Урсгал засвар	-	11,831.00	(11,831.00)
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	260,020.50	(260,020.50)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	260,020.50	(260,020.50)
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	4,000.00	(4,000.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,000.00	(4,000.00)
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	293,622.64	(293,622.64)
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	293,622.64	(293,622.64)
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	3,683.69	(3,683.69)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	283,913.75	(283,913.75)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	6,025.20	(6,025.20)

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Сумын төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд 2 төсвийн шууд захирагч, Засгийн газрын 3 тусгай сан, 1 ерөнхий орлогын дансны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нэгтгэгдсэн ба сумын боловсрол, соёл, эрүүл мэндийн 4 төсвийн шууд захирагчид олгосон тогтмол зардлын санхүүжилт, түүний зарцуулалттай холбоотой мэдээлэл санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн, мөнгөн гүйлгээний болон төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдсэн.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн хувьд 1 байгууллага дүгнэлт гаргах, 1 байгууллага болон 2 ЗГТС нь түүвэрт хамруулах хэлбэрээр хамрагдсан байна. Дүгнэлт гаргах сумын ЗДТГ-ын хувьд зөрчлийн дүн нь тогтоосон материаллаг түвшнээс өндөр байсан тул ХЯЗГААРЛАЛТТАЙ санал дүгнэлтийг хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагч, сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа.

Аудитаар нийт 9.6 сая төгрөгийн 3 алдаа илэрснээс аудитын явцад залруулсан ба алдааны товч утга, мэдээллийг аудитын тайлангийн 3 дугаар бүлэгт тусгасан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа.

Аудитаар санхүүгийн үр дүнгийн тайланд сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны зардлыг 182.5 сая төгрөгөөр илүү тайлагнаж, нэгтгэгдсэн байна.

Алдааны товч утга, мэдээллийг аудитын тайлангийн 3 дугаар бүлэгт тусгасан болно.

Төсвийн шууд захирагч, сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн зөрчил.

Аудитаар нийт 116.9 сая төгрөгийн 10 зөрчил илэрснээс 1.7 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 104.2 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, үнийн дүнгүй 1 хариуцлага тооцох албан шаардлага, 11.0 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн. Зөрчлийн товч утга, мэдээллийг аудитын тайлангийн 3 дугаар бүлэгт тусгасан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн зөрчил.

Аудитаар илэрсэн зөрчилгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын Тамгын газар	1	0.3	1	0.3			1	0.3				
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	1.8			1	1.8	1	1.8				
Орон нутгийн хөгжлийн сан	1	7.5			1	7.5	1	7.5				
Нэгтгэсэн тайлан	1	182.5			1	182.5	1	182.5				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>192.1</b>	<b>1</b>	<b>0.3</b>	<b>3</b>	<b>191.8</b>	<b>4</b>	<b>192.1</b>				

